



### НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2005 оны 6 сарын 22 өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

#### Хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг хувьчлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3, 81 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2004 оны 3/15 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 128, 141 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Нийслэлийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгох уралдаант шалгаруулалтын журмын дагуу явагдсан тендерийн ялагч багтай байгуулсан “Менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах гэрээ”-ний биелэлтийг үндэслэн “UBS” телевиз Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар, “Улаанбаатар таймс” Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар, “Улаанбаатар радио” Нийслэлийн өмчит төсөвт байгууллагыг хувьчилсугай

Хоёр. Нийслэлийн Засаг даргын 2004 оны 473 дугаар захирамжаар “Улаанбаатар радио” нийслэлийн өмчит төсөвт байгууллагад балансаас балансад шилжүүлсэн Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутагт байрлах “Баруун сэлбэ” үйлчилгээний төвийн “Ж” блокийн 1222.0 м2 талбай бүхий барилгын үнэлгээг тус байгууллагыг хувьчлах үнийн дүнд оруулж тооцохыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Өмч хувьчлах комиссын дарга / М. Энхболд/- зөвшөөрсүгэй.

Гурав. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Өмч хувьчлах комиссын дарга / М. Энхболд/- даалгасугай.



ДАРГА  
НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД:

<i>Н. Болормаа</i>	Н. БОЛОРМАА
<i>Т. Билэгт</i>	Т.БИЛЭГТ
<i>Ш. Алтангэрэл</i>	Ш.АЛТАНГЭРЭЛ
<i>Я. Аюушжав</i>	Я.АЮУШЖАВ
<i>Д. Баасансүрэн</i>	Д.БААСАНСҮРЭН
<i>С. Баярмөнх</i>	С.БАЯРМӨНХ
<i>Г. Мөнхбаяр</i>	Г.МӨНХБАЯР
<i>С. Отгонбат</i>	С.ОТГОНБАТ
<i>Б. Ундармаа</i>	Б.УНДАРМАА